



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/186

Арвайхээр

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
явуулах тухай

Монгол улсын "Газрын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 15 нэгж талбарын газрын, хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулна.

3. Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээг 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг цахимаар баталгаажуулан хүлээн авч товлосон хугацаанд дуудлага худалдааг зохион байгуулахыг Газрын даамал /Ш.Адъяадолгор, Н.Энхболд/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

37110037

Сумын Засаг даргын 2018 оны ... дугаар
сарын ... -ны өдрийн ... дугаар
захирамжийн ... дүгээр хавсралт



АРВАЙХЭЭР СУМАНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ГАЗРЫН БАЙРШИЛ,
ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Эзэмшүүлэх газрын байршил	Газар эзэмшүүлэх зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /га/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/	Дэнчингийн хэмжээ /мян.төг /
1	5 дугаар баг Дайрганы гол шувууны фермийн зүүн талд	Тахианы аж ахуй	1	6000.0	600.0
2	Ягаан толгойн гүүрний зүүн хойно	Үйлчилгээ	0.1	4000.0	400.0
3	Ягаан толгойн гүүрний зүүн хойно	Үйлчилгээ	0.1	4000.0	400.0
4	Өвсний фондны урд төв замын хойно	Үйлчилгээ	0.075	3000.0	300.0
5	Өвсний фондны урд төв замын хойно	Үйлчилгээ	0.075	3000.0	300.0
6	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
7	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
8	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
9	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
10	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
11	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
12	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
13	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
14	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
15	Түүхий эдийн зах	Түүхий эд авах цэг	0.05	1500.0	150.0
Нийт дүн			1.85	35000.0	3500.0

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР